



**Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд  
Корона вирус (COVID - 19) халдварын  
тархалтаас урьдчилан сэргийлэх, хөл  
хорио тогтоох арга хэмжээний үзүүлсэн  
нөлөөллийн тандалт судалгааны тайлан**

**УЛААНБААТАР ХОТ  
2021 он**

## АГУУЛГА

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ.....	2
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ .....	2
ОРШИЛ.....	3
СУДАЛГААНЫ ҮР ДҮН.....	5
1. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ.....	5
2. ОРЛОГОД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ.....	8
3. ҮЙЛДВЭРЛЭЛД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ .....	10
4. ЦАЛИНГИЙН ӨӨРЧЛӨЛТ .....	11
5. АЖИЛЛАХ ХҮЧИНД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ.....	11
6. ЗАСГИЙН ГАЗРААС ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНД ААН-ИЙН ӨГЧ БУЙ САНАЛ	15

## ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1 . ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД УЧИРЧ БУЙ ХҮНДРЭЛ, хамгийн их давтагдсан 5 шалтгаанаар, судалгаа явагдсан хугацаагаар, дүнд эзлэх хувиар	9
ХҮСНЭГТ 2 . ЦОМХОТГОЛ ХИЙСЭН ААН, ажиллагчдын тооны бүлгээр, дүнд эзлэх хувиар	12
ХҮСНЭГТ 3 . ӨНДӨРЖҮҮЛСЭН (БҮХ НИЙТИЙН) БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛСЭН ХУГАЦААГ СУНГАВАЛ ААН-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ, дүнд эзлэх хувиар	
ХҮСНЭГТ 4 . ӨНДӨРЖҮҮЛСЭН (БҮХ НИЙТИЙН) БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛСЭН ХУГАЦААГ СУНГАВАЛ ААН-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ, салбараар, дүнд эзлэх хувиар	

## ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, дүнд эзлэх хувиар, судалгаа явагдсан хугацаагаар.....	5
ЗУРАГ 2. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, дүнд эзлэх хувиар, салбараар, 2021 оны 8 дугаар сар.....	6
ЗУРАГ 3. ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХЭВИЙН, дүнд эзлэх хувиар, салбараар, 2021 оны 8-р сар.....	7
ЗУРАГ 4. ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХЭВИЙН БУС, дүнд эзлэх хувиар, салбараар, 2021 оны 8-р сар	7
ЗУРАГ 5. ААН-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД УЧИРЧ БУЙ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, шалтгаанаар, дүнд эзлэх хувиар.....	9
ЗУРАГ 6. ОРЛОГО БУУРСАН ААН-ИЙН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, салбараар.....	9
ЗУРАГ 7. ОРЛОГО БУУРСАН ААН, дүнд эзлэх хувиар, орлогын бүлгээр.....	10
ЗУРАГ 8. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХЭМЖЭЭ БУУРСАН ААН, дүнд эзлэх хувиар, бүлгээр.....	10
ЗУРАГ 9. ЦАЛИНГАА БУУРУУЛСАН ААН, бүлгээр, өмнөх судалгаануудын үр дүнтэй харьцуулснаар, дүнд эзлэх хувь.....	11
ЗУРАГ 10. АЖ АХУЙН НЭГЖ, ажиллагчдын тооны бүлгээр, дүнд эзлэх хувиар.....	12
ЗУРАГ 11. ААН-ИЙН ЦОМХОТГОЛ ХИЙСЭН БАЙДАЛ, дүнд эзлэх хувиар	14
ЗУРАГ 12. АЖИЛЛАГЧДАА ЦОМХОТГОХГҮЙ БАЙХ БОЛОМЖТОЙ ХУГАЦАА, дүнд эзлэх хувиар	15
ЗУРАГ 13. ААН-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХЭВИЙН ЯВУУЛАХАД ШААРДАГ ДАХ ХУГАЦАА, судалгаа явагдсан хугацаагаар, дүнд эзлэх хувиар.....	15

## ОРШИЛ

Үндэсний Статистикийн Хорооноос “Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Корона вируст (COVID - 19) халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний үзүүлсэн нөлөөлөл”-ийн 8 дах удаагийн тандалтын судалгааг 2021 оны 8 дугаар сарын 24-нөөс 9 дүгээр сарын 1-ний хооронд явуулж, үр дүнг танилцуулж байна.

Судалгааны зорилго нь Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос цар тахалтай холбоотой авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ ААН-ийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлоход чиглэгдсэн.

Дотоодын нийт бүтээгдэхүүн (үйлдвэрлэлийн аргаар тооцсон) 2021 оны эхний хагас жилд урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 19.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.7 их наяд төгрөг буюу 16.0 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр 12.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 739.0 тэрбум төгрөг буюу 6.3 хувиар тус тус өссөн байна.

Энэ оны 2 дугаар улирлын байдлаар статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй байгаа 210.9 мянган хуулийн этгээдийн 93.6 мянга буюу 44.4 хувь нь үйл ажиллагаа явуулж, 117.3 мянга буюу 55.6 хувь нь үйл ажиллагаа явуулаагүй байна. Үйл ажиллагаа явуулаагүй хуулийн этгээдийн 63.1 мянга буюу 53.8 хувь нь үйл ажиллагаа эхлээгүй бол 46.2 хувь нь бусад шалтгаантай байна. Үйл ажиллагаа эхлээгүй хуулийн этгээдийн эзлэх хувь 1.3 нэгж хувиар өссөн байна.

Ажиллах хүчний судалгааны 2021 оны 2 дугаар улирлын дүнгээр улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны нийт хүн амын 1.2 сая нь ажиллах хүч байна. Ажиллах хүчний 1.1 сая буюу 91.6 хувь нь ажиллагчид, тэдгээрийн 2.8 мянга буюу 0.3 хувь нь хөдөлмөрийн дутуу ашиглалтын нэг бүлэг болох цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2021 оны эхний 8 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 12.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.7 их наяд төгрөг буюу 28.0 хувиар өслөө. Үүнээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 1.9 их наяд төгрөг буюу 29.9 хувиар, боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 637.9 тэрбум төгрөг буюу 28.7 хувиар тус тус өссөн байна. Мөн цахилгаан хий, уур, агааржуулалтын салбарын үйлдвэрлэл 86.8 тэрбум төгрөг буюу 11.2 хувиар, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарын үйлдвэрлэл 14.9 тэрбум төгрөг буюу 16.9 хувиар өссөн байна.

Худалдааны салбарын нийт борлуулалт 2021 оны эхний 7 сард 14.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.5 их наяд төгрөг буюу 21.7 хувиар өслөө. Өмнөх оны мөн үеэс шатахууны жижиглэн худалдаа 14.0 хувиар, бөөний худалдаа 28.5 хувиар, хүнс, ундаа, тамхины бөөний худалдаа 21.6 хувиар, хүнсний төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа 13.3 хувиар, моторт тээврийн хэрэгслийн худалдаа 12.7 хувиар тус тус өссөн нь байна.

Нийтийн хоолны салбарын орлого 2021 оны эхний 7 сард 282.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 48.4 тэрбум төгрөг буюу 14.6 хувиар буурчээ. Зочид буудлын салбарын орлого 2021 оны эхний 7 сард 84.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6.8 тэрбум төгрөг буюу 7.4 хувиар буурсан байна.

Энэ удаагийн судалгаагаар 2021 оны 6-8 дугаар саруудын ААН-ийн үйл ажиллагааны нөхцөл байдлын талаарх мэдээллийг цуглуулсан бөгөөд нийт 2394 ААН хамрагдсан.

Монгол Улсад Корона вируст (Covid-19) халдвар бүртгэгдсэн анхны тохиолдлоос эхлэн Засгийн газраас халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зэрэг арга хэмжээг зохион байгуулж байна.

Монгол Улсын Засгийн газраас 2021 онд:

- Монгол Улсын Засгийн газрын 1 дүгээр сарын 4-ний өдрийн “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 1 дүгээр тогтоолоор 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийг дуустал,
- Монгол Улсын Засгийн газрын 2 дугаар сарын 10-ны өдрийн “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх тухай” 27 дугаар тогтоолоор 2 дугаар сарын 11-ний өдрөөс 23-ны өдрийг дуустал,
- Монгол Улсын Засгийн газрын 4 дүгээр сарын 8-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор 4 дүгээр сарын 10-ны өдрөөс 5 дугаар сарын 8-ны өдрийг хүртэл “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” шийдвэрийг гаргасан.

## ТОВЧ ҮР ДҮН

Монгол Улсын Засгийн газраас корона вируст халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний дагуу энэ оны 5 сараас хөл хорио тогтоох арга хэмжээг сулруулж, үйл ажиллагааг түр зогсоосон байсан ААН-үүдийн үйл ажиллагааг үе шаттайгаараа нээх шийдвэр гарсан. Үүнтэй холбоотойгоор үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа ААН-ийн тоо өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад нэмэгдсэн байна.

Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн 50-иас дээш хувиар үйлдвэрлэл нь буурсан ААН-ийн эзлэх хувь буурсан ч эсрэгээрээ 50-иас дээш хувиар орлого нь буурсан ААН-ийн тоо өссөн байна. ААН-үүд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн хэдий ч үйлчлүүлэгчдийн тоо эрс буурсан болон санхүүгийн байдал нь хүндэрсэн байдал хэвээр байгаа нь ажиглагдаж байна.


Засгийн газраас цар тахлын нөлөөлөлд ихээхэн өртөж үйл ажиллагаанд нь хохирол учирсан ААН-үүдэд үйл ажиллагааг нь сэргээхэд чиглэсэн арга хэмжээг авах, тэр дундаа санхүүгийн дэмжлэг болон татварын хөнгөлөлт үзүүлэх шаардлагатай байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

## СУДАЛГААНЫ ҮР ДҮН

### 1. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

Судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн 66.1 хувь нь 2021 оны 6-8 дугаар сард үйл ажиллагаа нь хэвийн үргэлжилсэн байхад 33.9 хувь нь хэвийн бус байна. Үйл ажиллагаа эрхлэлтийн байдлыг 2021 оны 5 дугаар сарын байдалтай харьцуулахад үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа ААН-ийн эзлэх хувь 12.1 нэгж хувиар өссөн байна. Энэ нь Улаанбаатар хотод 5 дугаар сарын 10-наас эхлэн хатуу хөл хориог цуцалж, ААН-үүдийн үйл ажиллагааг үе шаттайгаар нээсэнтэй холбоотой юм.


ЗУРАГ 1. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, дүнд эзлэх хувиар, судалгаа явагдсан хугацаагаар



Үйл ажиллагаа эрхлэлтийн байдлыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд судалгаанд хамрагдсан санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг ААН-ийн 84.0 хувь, бөөний болон жижиглэн худалдаа эрхэлдэг ААН-ийн 79.1 хувь, хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа эрхэлдэг ААН-ийн 75.7 хувь, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас, ан агнуурын үйл ажиллагаа эрхэлдэг ААН-ийн 75.0 хувь нь тус тус үйл ажиллагаа хэвийн явагдаж байна гэж хариулсан байна.


Харин боловсролын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг ААН-ийн 45.0 хувь, урлаг, үзвэр, тоглоомын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ААН-ийн 41.7 хувь, аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг ААН-ийн 17.6 хувь нь л үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа гэж хариулсан байна (ЗУРАГ 2).

ЗУРАГ 2. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, дүнд эзлэх хувиар, салбараар, 2021 оны 8 дугаар сар




Үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа гэж хариулсан ААН-ийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд 29.4 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ, 13.3 хувь нь барилга, 7.7 хувь нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, 7.4 хувь нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, 5.1 хувь нь хүний эрүүл мэнд, үлдсэн хувь нь бусад салбарт үйл ажиллагаа явуулж байна (ЗУРАГ 3).

ЗУРАГ 3. ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХЭВИЙН, дүнд эзлэх хувиар, салбараар, 2021 оны 8-р сар,



Үйл ажиллагаа нь хэвийн бус гэж хариулсан ААН-ийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 16.2 хувь нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, 15.2 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ, 11.2 хувь нь барилга, 10.9 хувь нь боловсрол, 9.7 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 6.9 хувь нь аялал жуулчлал, үлдсэн хувь нь бусад салбарт үйл ажиллагаа явуулж байна (ЗУРАГ 4).

ЗУРАГ 4. ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХЭВИЙН БУС, дүнд эзлэх хувиар, салбараар, 2021 оны 8 дугаар сар



Цар тахлын улмаас Монгол Улсын Засгийн газраас “Өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэнтэй холбоотойгоор “Үйл ажиллагаа нь хэвийн бус” явагдсан гэж хариулсан ААН-ийн үйл ажиллагаанд хүндрэл учирсан гэж 70.5 хувь нь хариулжээ. Энэ нь 5 дугаар сард явагдсан судалгааныхаас 3.2 нэгж хувиар өссөн нь үйл ажиллагаа явуулахад хүндрэл нэмэгдэж байгааг илтгэж байна.



## 2. ОРЛОГОД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Үйл ажиллагаа нь хэвийн бус явагдсан ААН-ийн хувьд тулгарч буй хүндрэлийг судлахад 72.9 хувь нь санхүүгийн байдал хүндэрсэн, 56.5 хувь нь үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан, 43.9 хувь нь ажиллагчдынхаа цалинг олгох, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон, 35.0 хувь нь үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ эрс буурсан, 32.7 хувь нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, бусад татвар, хураамжийг төлөхөд хүндрэлтэй болсон, 30.9 хувь нь түүхий эд, материал, барааны эргэлт удааширч, хомсдол үүссэн, 30.2 хувь нь зээл, зээлийн хүү төлөхөд хүндрэлтэй болсон гэж хариулжээ (Зураг 5).

ЗУРАГ 5. ААН-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД УЧИРЧ БУЙ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, ШАЛТГААНААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР



Тайлбар: Хариулт нь олон сонголттой бөгөөд олон давтагдсанаар нь эрэмбэлсэн.

Үйл ажиллагаа нь хэвийн бус явагдсан ААН-д тулгарсан хүндрэл бэрхшээлийг 5 дугаар сарынхтай харьцуулахад “Санхүүгийн байдал хүндэрсэн” гэж хариулсан ААН-ийн эзлэх хувь 3.4 нэгж хувиар, “Ажиллагчдынхаа цалинг олгох, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон” гэж хариулсан ААН-ийн эзлэх хувь 0.8 нэгж хувиар тус тус өссөн байна. Харин “Үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ эрс буурсан” гэж харилсан ААН-ийн эзлэх хувь 4.0 нэгж хувиар, “Үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан” гэж хариулсан ААН-ийн эзлэх хувь 3.4 нэгж хувиар, “ААН-ийн орлогын албан татвар, бусад татвар хураамжийг төлөхөд хүндрэлтэй болсон” гэж хариулсан ААН-ийн эзлэх хувь 1.8 нэгж хувиар тус тус буурсан байна.


ХҮСНЭГТ 1. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД УЧИРЧ БУЙ ХҮНДРЭЛ, хамгийн их давтагдсан 5 шалтгаанаар, судалгаа явагдсан хугацаагаар, дүнд эзлэх хувиар

	2021.III	2021.IV	2021.V	2021.VIII
Санхүүгийн байдал хүндэрсэн	70.3	70.3	69.5	72.9
Үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан	62.2	62.2	59.9	56.5
Ажиллагчдынхаа цалинг олгох, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон	40.6	40.6	43.1	43.9
Үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ эрс буурсан	36.0	36.0	39.0	35.0
ААН-ийн орлогын албан татвар, бусад татвар хураамжийг төлөхөд хүндрэлтэй болсон	33.3	33.3	34.5	32.7

Үйл ажиллагаа явуулахад хүндрэл учирсан гэж хариулсан ААН-ийн 78.1 хувь нь Монгол Улсын Засгийн газраас “Өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлснээс шалтгаалан өмнөх 3 сараас буюу 3-5 дугаар сараас “Орлого буурсан” гэж хариулсан бол 21.9 хувь нь орлого буураагүй гэж хариулсан байна. Орлого буурсан гэж хариулсан ААН-ийн эзлэх хувь өмнөх сарын судалгааны үр дүнтэй харьцуулахад 2.1 нэгж хувиар буурсан байна.


Орлого нь буурсан ААН-ийг салбараар авч үзэхэд 21.6 хувийг зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, 15.3 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ, 10.7 хувийг боловсрол, 10.4 хувийг барилга, 10.2 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 7.0 хувийг тээвэр, агуулахын үйл ажиллагаа, 6.5 хувийг аялал жуулчлалын үйл ажиллагаа, 18.3 хувийг бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг ААН-үүд эзэлж байна.

ЗУРАГ 6. ОРЛОГО БУУРСАН ААН-ИЙН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, салбараар



Энэ оны 6-8 дугаар сард үйл ажиллагаа нь хүндэрч “Орлого буурсан” ААН-үүдийг бүлэглэж авч үзвэл, орлого нь 50-иас дээш хувиар буурсан ААН 66.2 хувь, 41-50 хувиар буурсан ААН 9.6 хувь, 31-40 хувиар буурсан ААН 8.5 хувь, 21-30 хувиар буурсан ААН 8.3 хувь, 11-20 хувиар буурсан ААН 4.0 хувь, 10 хүртэл хувиар буурсан ААН 3.4 хувийг тус тус эзэлж байна.

ЗУРАГ 7. ОРЛОГО БУУРСАН ААН, дүнд эзлэх хувиар, орлогын бүлгээр




Энэ оны 3-5 дугаар сартай харьцуулахад 10 хүртэл хувиар орлого нь буурсан ААН-ийн эзлэх хувь 1.3 нэгж хувиар, 21-30 хувиар орлого нь буурсан ААН-ийнх 0.7 нэгж хувиар тус тус өссөн бол орлого нь 31-40 хувиар буурсан ААН-ийнх 1.4 нэгж хувиар, 41-50 хувиар буурсан ААН-ийнх 0.1 нэгж хувиар, 50 дээш хувиар буурсан ААН-ийнх 0.5 нэгж хувиар тус тус буурсан байна (Зураг 7).

### 3. ҮЙЛДВЭРЛЭЛД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Засгийн газраас “Өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэнтэй холбоотойгоор 2021 оны 6-8 дугаар сард үйл ажиллагаанд нь хүндрэл учирсан ААН-ийн 75.7 хувийнх нь үйлдвэрлэл өмнөх 3 сарынхаас буурсан бол 24.3 хувь нь үйлдвэрлэл буураагүй гэж хариулсан байна.

ЗУРАГ 8. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХЭМЖЭЭ БУУРСАН ААН, дүнд эзлэх хувиар, бүлгээр




ААН-үүдийн үйлдвэрлэлийн бууралтыг 2021 оны өмнөх 3 сартай харьцуулахад 10 хүртэл хувиар буурсан ААН-ийн эзлэх хувь 2.2 нэгж хувиар, 41-50 хувиар буурсан ААН-ийнх 0.8 нэгж хувиар тус тус өссөн бол үйлдвэрлэл нь 11-20 хувиар буурсан ААН-ийнх 0.7 нэгж хувиар, 21-30 хувиар буурсан ААН-ийнх 0.6 нэгж хувиар, 31-40 хувиар буурсан ААН-ийнх 1.4 нэгж хувиар, 50 хувиас дээш хувиар буурсан ААН-ийнх 0.3 нэгж хувиар тус тус буурсан байна (Зураг 8)

#### 4. ЦАЛИНГИЙН ӨӨРЧЛӨЛТ

Үйл ажиллагаанд нь хүндрэл учирсан ААН-ийн 38.8 хувь нь ажиллагчдынхаа цалинг 6-8 дугаар сард бууруулсан бол 61.2 хувь нь цалин бууруулах арга хэмжээ аваагүй байна.

Цалингаа бууруулах арга хэмжээ авсан нийт ААН-ийн 50.6 хувь нь 50-иас дээш хувиар цалингаа бууруулсан бол, 7.1 хувь нь 31-40 хувиар, 6.5 хувь нь 21-30 хувиар, 6.5 хувь нь 11-20 хувиар, 6.0 хувь нь 41-50 хувиар, 1.8 хувь нь 10 хүртэл хувиар цалингаа бууруулсан байна. Харин 21.4 хувь нь ажиллагчиддаа цалингаа ажилласан цагаар нь (хийснээр нь) олгосон байна.

ЗУРАГ 9. ЦАЛИНГАА БУУРУУЛСАН ААН, бүлгээр, өмнөх судалгаануудын үр дүнтэй харьцуулснаар, дүнд эзлэх хувь




Энэ оны 6-8 дугаар сард цалингаа 31-40 хувиар бууруулсан ААН-ийн эзлэх хувь өмнөх 3 сарынхтай харьцуулахад 1.3 нэгж хувиар, 21-30 хувиар бууруулсан ААН-ийнх 1.2 нэгж хувиар, 11-20 хувиар бууруулсан ААН-ийнх 0.9 нэгж хувиар, 10 хүртлэх хувиар бууруулсан ААН-ийнх 0.2 нэгж хувиар, цалингаа ажилласан цагаар нь буюу хийснээр нь олгосон ААН-ийнх 1.0 нэгж хувиар тус тус өссөн байна. Харин цалингаа 50-иас дээш хувиар бууруулсан ААН-ийн эзлэх хувь 3.1 нэгж хувиар, 41-50 хувиар бууруулсан ААН-ийнх 1.5 нэгж хувиар буурсан байна.


#### 5. АЖИЛЛАХ ХҮЧИНД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн 71.3 хувь нь 1-9 ажиллагчидтай, 13.5 хувь нь 10-19 ажиллагчидтай, 7.4 хувь нь 20-49 ажиллагчидтай, 7.9 хувь нь 50-иас дээш тооны ажиллагчидтай байна.

ЗУРАГ 10. АЖ АХУЙН НЭГЖ, ажиллагчдын тооны бүлгээр, дүнд эзлэх хувиар



ЗУРАГ 11. ААН-ИЙН ЦОМХОТГОЛ ХИЙСЭН БАЙДАЛ, дүнд эзлэх хувиар




Судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн 7.7 хувь нь 2021 оны 6-8 дугаар сард ажиллагчдаа цомхотгох арга хэмжээ авсан бол 92.3 хувь ажлын байраа хадгалж үлдсэн байна. Цомхотгол хийсэн ААН-ийг ажиллагчдын тооны бүлгээр авч үзэхэд 1-9 ажиллагчидтай ААН 91.4 хувь, 10-19 ажиллагчидтай ААН 4.9 хувь, 20-29 ажиллагчидтай ААН 1.6 хувь, 30-39 ажиллагчидтай ААН 1.1 хувь, 40-өөс дээш тооны ажиллагчидтай ААН 1.1 хувийг тус тус эзэлж байна. Үүнээс харахад цар тахлаас урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээ нь жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 2 . ЦОМХОТГОЛ ХИЙСЭН ААН, ажиллагчдын тооны бүлгээр, дүнд эзлэх хувиар

	2021.III	2021.IV	2021.V	2021.VIII
Бүгд	100.0	100.0	100.0	100.0
1-9 ажиллагч	92.7	86.3	94.4	91.4
10-19 ажиллагч	3.8	8.7	4.6	4.9
20-29 ажиллагч	1.3	2.2	0.5	1.6
30-39 ажиллагч	1.3	0.5	0.0	1.1
40-өөс дээш ажиллагч	0.9	2.2	0.5	1.1

Цаашид хэдий хугацаанд ажиллагчдаа цомхотгохгүй байх боломжтойг тодруулан асуухад судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн 50.2 хувь цомхотгол хийхгүй, 33.2 хувь нь тодорхойгүй, 9.3 хувь 3 хүртлэх сар, 4.8 хувь нь 3-6 сар, 2.4 хувь нь 6-12 сарын хугацаанд цомхотгол хийхгүй байх боломжтой гэж хариулжээ (Зураг 12).

ЗУРАГ 12. АЖИЛЛАГЧДАА ЦОМХОТГОХГҮЙ БАЙХ БОЛОМЖТОЙ ХУГАЦАА, дүнд эзлэх хувиар



## 6. ЗАСГИЙН ГАЗРААС ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНД ААН-ИЙН ӨГЧ БУЙ САНАЛ

Судалгаанд хамрагдсан ААН-ийн 55.4 хувь нь цаашид Засгийн газраас өндөржүүлсэн (бүх нийтийн) бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгавал ААН-ийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө маш ихтэй гэж үзжээ. Харин 5.1 хувь нь ямар нэг нөлөө үзүүлэхгүй гэж хариулжээ.

ХҮСНЭГТ 3 . ӨНДӨРЖҮҮЛСЭН (БҮХ НИЙТИЙН) БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛСЭН ХУГАЦААГ СУНГАВАЛ ААН-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ, дүнд эзлэх хувиар

	2021 I	2021 II	2021 III	2021 IV	2021 V	2021 VIII
	дүнд эзлэх хувь					
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Сөрөг нөлөө маш их	56.1	57.3	61.7	62.6	65.7	55.4
Сөрөг нөлөө дунд зэрэг	26.9	26.7	26.5	24.4	23.7	27.8
Сөрөг нөлөө бага	12.1	10.0	8.4	8.6	7.5	11.7
Ямар нэг нөлөө үзүүлэхгүй	4.9	6.1	3.4	4.5	3.1	5.1

Цаашид Засгийн газраас өндөржүүлсэн (бүх нийтийн) бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгавал ААН-ийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө маш ихтэй гэж хариулсан ААН-ийг салбараар авч үзэхэд 19.2 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ, 14.2 хувь нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, 12.4 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 10.9 хувь нь барилга, 8.9 хувь нь боловсрол, үлдсэн хувь нь бусад салбарт үйл ажиллагаа явуулж байна.

ХҮСНЭГТ 4. ӨНДӨРЖҮҮЛСЭН (БҮХ НИЙТИЙН) БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛСЭН ХУГАЦААГ СУНГАВАЛ ААН-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ, салбараар, дүнд эзлэх хувиар

	Сөрөг нөлөө маш их	Сөрөг нөлөө дунд зэрэг	Сөрөг нөлөө бага	Ямар нэг нөлөө үзүүлэхгүй
Бүгд	100.0	100.0	100.0	100.0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	19.2	30.5	37.9	20.3
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	14.2	6.9	5.4	3.3
Боловсруулах үйлдвэрлэл	12.4	13.4	7.9	11.4
Барилга	10.9	7.5	5.7	5.7
Боловсрол	8.9	4.4	2.5	4.9
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	5.5	5.0	4.6	4.1
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	5.1	7.1	9.3	13.0
Аялал жуулчлал	4.8	0.5	0.7	-
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	3.7	4.2	4.3	14.6
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	3.0	3.9	2.5	-
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	3.0	2.7	4.3	2.4
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2.9	5.4	5.7	3.3
Уул уурхай, олборлолт	1.8	3.3	2.5	-
Урлаг, үзвэр, тоглоом	1.7	0.2	-	-
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1.5	0.9	-	3.3
Мэдээлэл, холбоо	0.7	2.0	2.1	2.4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.4	0.5	0.7	1.6
Цахилгаан, хий, агааржуулалт	0.4	1.2	3.2	9.8
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	0.1	0.6	0.7	-

Цар тахлын улмаас “Өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэнтэй холбоотойгоор ААН-д үүсээд буй хүндрэл бэрхшээлийг даван туулахад Засгийн газраас ямар төрлийн дэмжлэг шаардлагатай байгааг тодруулахад 63.2 хувь нь үйл ажиллагаагаа сэргээхэд гарах асуудлуудыг төрийн бодлогоор шуурхай шийдэхэд дэмжлэг үзүүлэх, 55.2 хувь нь зээл авах боломжийг бий болгох бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, 47.1 хувь нь эрсдэл, гамшгийн үед ААН-ийн үйл ажиллагаа эдийн засагт учирч болох болзошгүй аюулаас сэргийлэх, даван туулах стратеги, бодлогыг боловсруулах гэж хариулжээ.

Өндөржүүлсэн (бүх нийтийн) бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг цуцалсны дараа үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай хугацааг асуухад 28.2 хувь тодорхойгүй, 5.9

хувь нь 1 жилээс дээш хугацаа шаардлагатай гэсэн бол харин 23.1 хувь нь одоогоор үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа гэж хариулжээ.

ЗУРАГ 13. ААН-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХЭВИЙН ЯВУУЛАХАД ШААРДАГДАХ ХУГАЦАА, судалгаа явагдсан хугацаагаар, дүнд эзлэх хувиар

